



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 0/63

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн
улсын үзлэг тооллогын комисс
байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулий 72 дугаар зүйлийн 72.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан Бэлчээрийн менежмент төслийн нэгж, орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 2.3, 5.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг удирдан зохион байгуулж явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг 2022 оны 04 сарын 10-ны өдрөөс эхлэн заасан хугацаанд багтааж чанартай зохион байгуулж дуусгахыг тооллогын комисст үүрэг болгосугай.


3.Төрийн өмчийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулж, хяналт тавих, санхүүгийн тайланд бүртгэлтэй дүн мэдээг танилцуулахыг тооллогын комисст (Г.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон
нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын
даргын 2022 оны ... дугаар сарын ... – ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



БАЙГУУЛЛАГЫН 2022 ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫГ УДИРДАН
ЯВУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Төслийн менежер

Гишүүдэд:

Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн

Механик инженер

Нягтлан бодогч


Тоног төхөөрөмжийн оператор

Нярав

Нарийн бичгийн дарга:

Агрономч

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 09 ны өдрийн 1/03 дугаар тушаалын хавсралт



ӨМЧИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ ХАНГАХТАЙ ХОЛБООТой ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ /2022 он/

2022.03.09

№	Ерөнхий хийгдэх ажил	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах	Ажлын хэсгийг 5-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй байгуулах	I улиралд	Дарга, Төслийн менежер, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн,
		ӨХЗ-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулах	I улиралд	Дарга, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн, ӨХЗ
2	Байгууллагын улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийг “ХУР” систем дэх мэдээлэлтэй тулган үнэн зөв болгох	Бүртгэлтэй холбоотой мэдээллийг тулгаж баталгаажуулах	II улиралд	Механик, Нягтлан бодогч, /Ажлын хэсэг/
3	Газрын гэрчилгээ, гэрээ кадастрын зургийг QR кодтойгоор “EGAZAR” системээс хэвлэн авах, гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг дээрх талбайн хэмжээ адил, үнэн зөв байх, санхүүгийн тайланд тусгасан газар эзэмших эрхийн нэгж, талбарын мэдээлэл нь газрын цахим мэдээллийн сангийн мэдээлэлтэй тохирч байх, хэрэв зөрчилтэй байвал зөрчлийг арилгуулах	Байгууллагын 90 үхрийн аж ахуй байрладаг 1 га газрын гэрчилгээг байгууллагын өөрийн нэрлүү шилжүүлэх ажлыг хийх	II улиралд	Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн, /Ажлын хэсэг/
4	Байгууллагын эзэмшил ашиглалтанд буй тээврийн хэрэгслийн мэдээллийг “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын улсын нэгдсэн мэдээллийн систем дэх мэдээлэлтэй тулгах, зөрүүтэй мэдээлэл гарвал холбогдох өөрчлөлтийг хийлгүүлж үнэн зөв болгох	Холбоотой ажлыг хийж, бэлтгэлийг хангаж дуусгах	I улиралд	Нягтлан бодогч, Механик, /Ажлын хэсэг/
5	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын болон жолоочийн зөрчлийн торгуулийн төлбөртэй эсэх, төлбөр тооцоотой бол барагдуулах	Холбоотой ажлыг хийж, бэлтгэлийг хангаж дуусгах	I улиралд	Нягтлан бодогч, /Ажлын хэсэг/
6	Барилга хот байгуулалтын Сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтлөх журмын дагуу үнэн зөв хөтөлсөн эсэхийг хянан үзэх, хөтлөх, холбогдох схем болон фото зургуудыг бэлтгэх	Холбоотой ажлыг хийж, бэлтгэлийг хангаж дуусгах	I улиралд	Механик, Нягтлан бодогч, /Ажлын хэсэг/
7	Эзэмшил газрын нэгж талбар бүр дээрх барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн байршил, заагийг харуулсан орчны тойм зургийг үйлдэх	Холбоотой ажлыг хийж, бэлтгэлийг хангаж дуусгах	I улиралд	Ажлын хэсэг